



ДИ БИ ЭМ АССЕТ МЕНЕЖМЕНТ УЦК ХХК-ИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

20~~22~~ оны 09. сарын 15. өдөр

№ 08/22

Улаанбаатар хот

Г “Ди Би Эм ассет менежмент УЦК” ХХК-ийн 7  
Ногдол ашгийн бодлого батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13 дахь заалт, Компанийн дүрмийн 12.1.10, 12.1.21 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ Нь:

- “Ди Би Эм ассет менежмент УЦК” ХХК-ийн “Ногдол ашгийн бодлого”-ыг энэхүү тогтоолын хавсралтаар баталсугай.
- “Ногдол ашгийн бодлого”-ыг батлагдсан өдрөөс эхлэн үйл ажиллагаандaa чанд мөрдөж ажиллахыг гүйцэтгэх захирал /Д.Мөнхбат/-д даалгасугай.
- Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг хяналт, шалгалт хариуцсан ажилтанд даалгасугай.



Л.ТЭМҮҮЖИН



Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны  
09 дугаар сарын 15-ны өдрийн 08/22  
дугаар тогтоолын Хавсралт ОФ

## НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО

Баримтын хувилбар 1.0

Огноо 2022/09/15

Журмын код: .....

Компанийн дотоод хэрэгцээнд ашиглана.








Хамрах хүрээ: "Ди Би Эм ассет менежмент УЦК" ХХК	Журмын код: .....
Хариуцах эзэн: ТУЗНБДарга	Танилцах: ТУЗ, ТУЗНБД, Компанийн эрх бүхий этгээд
Баталсан огноо: 2022/08/....	Хуудас 2 /6

### БАРИМТ БИЧИГТ ОРСОН ӨӨРЧЛӨЛТҮҮД

ЖУРМЫГ БАТАЛСАН:

ОГНОО	ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭД	Гарын үсэг
2022/.... /....	Л.Тэмүүжин (ТУЗ-ийн дарга)	

ЖУРМЫГ ХЯНАСАН:

ОГНОО	ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭД	Гарын үсэг
2022/ ..../....	Д.Мөнхбат (Гүйцэтгэх захирал)	
2022/ ..../....	М.Жавхлан (Сангийн менежер)	
2022/ ..../....	Ш. Мөнхцэцэг (Захиргаа, хүний нөөцийн ахлах мэргэжилтэн)	
2022/ ..../....	Э.Хулан (Хөрөнгө оруулагч, олон нийтийн харилцаа хариуцсан мэргэжилтэн)	
2022/ ..../....	М.Түвшинбагана (ТХН-ийн санхүүгийн шинжээч)	
2022/ ..../....	Н.Нарангэрэл (ТХН-ийн худалдан авалтын мэргэжилтэн)	
2022/ ..../....	С.Алтантуяа (ТХН-ийн нягтлан бодогч)	

ЖУРМЫГ БОЛОВСРУУЛСАН:

ХУВИЛБАР №	ОГНОО	АЖИЛТАН	ТАЙЛБАР
1.0	2022.08.24	Д.Нэрэнцогт (ТХН-ийн хуулийн зөвлөх)	2022 оны Компанийн засаглалын кодексийн үлгэрчилсэн загвар болон компанийн 2018 онд боловсруулж байсан загвар болон Компанийн тухай хууль тогтомжийг суурилан боловсруулав..

Хамрах хүрээ: “Ди Би Эм ассет менежмент УЦК” ХХК	Журмын код: .....
Хариуцах эзэн: ТУЗНБДарга	Танилцах: ТУЗ, ТУЗНБД, Компанийн эрх бүхий этгээд
Баталсан огноо: 2022/08/....	Хуудас 3 /6

## АГУУЛГА

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ  
 ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА  
 ГУРАВ. ХАРИУЦЛАГА  
 ДӨРӨВ. БУСАД



И БИ :  
ГЕЖМІ

182561

Хамрах хүрээ: “Ди Би Эм ассет менежмент УЦК” ХХК	Журмын код: .....
Хариуцах эзэн: ТУЗНБДарга	Танилцах: ТУЗ, ТУЗНБД, Компанийн эрх бүхий этгээд
Баталсан огноо: 2022/08/....	Хуудас 4 /6

## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү “Ногдол ашгийн бодлого” (цаашид “бодлого” гэх) нь “Ди Би Эм ассет менежмент УЦК” ХХК (цаашид “Компани” гэх)-ийн ногдол ашгийн бодлогын баримт бичиг бөгөөд ногдол ашиг хуваарилах эсэх шийдвэр гаргах, хуваарилах ногдол ашгийн хэмжээ, хуваарилах нөхцөл журмыг тодорхойлох, хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх, тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулна.
- 1.2 Монгол Улсын Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 145 дүгээр тогтоолоор батлагдсан “Компанийн засаглалын кодекс”, 2022 оны 276 дугаар тогтоолоор батлагдсан “Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”, Компанийн дүрэм болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд төлөөлөн удирдах зөвлөлөөс энэхүү журмыг баталж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгоно.

## ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 2.1 Компанийн ногдол ашгийн бодлого нь компанийн үйл ажиллагаа болон стратегийн бодлоготой уялдсан байна.
- 2.2 Компани нь ногдол ашиг хуваарилахдаа Компанийн тухай хууль, холбогдох журамд заасан нөхцөл шаардлагыг хангасан байна.
- 2.3 Компани нь татвар төлсний дараах цэвэр ашгаас хувьцаа эзэмшигчид ногдол ашиг хуваарилахдаа дараах зарчмыг баримтална:
  - 2.3.1 ногдол ашиг төлсний дараа компани төлбөрийн чадвартай байх;
  - 2.3.2 ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгө нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, татан буулгалтын үнэ зэргийн нийлбэрээс их байх;
  - 2.3.3 компани эргүүлэн авах үүрэг хүлээсэн үнэт цаасаа бүрэн авсан байх.
- 2.4 Компани нь давуу эрхийн хувьцаанд ногдол ашиг хуваарилахдаа Компанийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.3-дэх хэсэгт заасныг баримтлана.
- 2.5 Ногдол ашиг тараах хэлбэр ба хугацаа нь хувьцаа эзэмшигчдийн эрх ашигт нийцсэн, холбогдох хууль тогтоомж, эрх бүхий байгууллагын баталсан журам, зааврыг зөвлөмжийг дагаж мөрднө.
- 2.6 Нэгж хувьцаанд хуваарилах ногдол ашгийн хэмжээг тухайн санхүүгийн жилийн татвар төлсний дараах цэвэр ашгийн хэмжээ, компанийн богино болон дунд, урт хугацааны стратеги төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлага зэргийг

Хамрах хүрээ: “Ди Би Эм ассет менежмент УЦК” ХХК	Журмын код: .....
Хариуцах эзэн: ТУЗНБДарга	Танилцах: ТУЗ, ТУЗНБД, Компанийн эрх бүхий этгээд
Баталсан огноо: 2022/08/....	Хуудас 5 /6

Үндэслэн төлөөлөн удирдах зөвлөл тогтооно. Тооцооллыг гүйцэтгэх удирдлагаас санал болгож болно.

- 2.7 Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (Цаашид “ТУЗ” гэх) нь компанийн хагас жилийн санхүүгийн үр дүнг харгалзан ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэж болно. Энэ тохиолдолд уг шийдвэрийг хагас жилийн санхүүгийн тайлан гарснаас хойш 30 хоногийн дотор гаргах ба энэхүү баримт бичгийн 2.3-т заасан нөхцөл хангагдсан байна.
- 2.8 ТУЗ-өөс ногдол ашгийг тараах өдрийг тогтоохдоо компанийн бизнес төлөвлөгөөтэй уялдуулан боломжит хугацааг харгалзана.
- 2.9 Ногдол ашиг хуваарилалтын тайланг холбогдох журмын дагуу гарган Санхүүгийн зохицуулах хороо болон үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлэхээс гадна хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд өмнөх жилийн ногдол ашиг хуваарилалтын тайланг заавал тайлagnana.
- 2.10 Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэр гарсан үел төлбөл зохих ногдол ашгийн хэмжээг хувьцаа эзэмшигчдэд төлөх өр болгон нягтлан бодох бүртгэлд тусгана.
- 2.11 Компани нь өөрийн цахим хуудсанд ногдол ашгийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг байршуулна.

## ГУРАВ. ХАРИУЦЛАГА

- 3.1 Компани нь өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдэд ногдол ашгийг хугацаанд нь тараагаагүй тохиолдолд хувьцаа эзэмшигчийн нэхэмжлэлээр алданги төлөх ба компанийд учирсан хохирлыг гүйцэтгэх захирал хариуцна.

## ДӨРӨВ. БУСАД

- 4.1 Энэхүү журмаар зохицуулагдаагүй асуудлыг тухайн асуудлын талаарх тусгайлан зохицуулсан холбогдох хууль тогтоомж, дүрэм журмаар, эсвэл компанийн удирдлагын шийдвэрээр зохицуулна.

--00--

Хамрах хүрээ: “Ди Би Эм ассет менежмент УЦК” ХХК	Журмын код: .....
Хариуцах эзэн: ТУЗНБДарга	Танилцах: ТУЗ, ТУЗНБД, Компанийн эрх бүхий этгээд
Баталсан огноо: 2022/08/....	Хуудас 6 /6

**ЖУРМЫН БҮРТГЭЛИЙН ХУУДАС**

№	ОГНОО	ТАНИЛЦСАН АЖИЛТНЫ НЭР	ТАНИЛЦСАН АЖИЛТНЫ ГАРЫН ҮСЭГ	ТАЙЛБАР

---

ЭНЭХҮҮ ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧГИЙГ “ДИ БИ ЭМ АССЕТ МЕНЕЖМЕНТ УЦК” ХХКОМПАНИЙН ЗӨВШӨӨРӨЛГҮЙГЭЭР  
АШИГЛАХ, ТҮГЭЭХ, ТАРААХ, НИЙТИЙН ХҮРТЭЭЛ БОЛГОХЫГ ХОРИГЛОНО.